



## БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 24 өдөр


Дугаар 206

Улаанбаатар хот

Барилгын тусгай зөвшөөрлийг сунгах,  
нэмэлт ажлын төрлөөр олгох,  
шинээр олгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.14.3, 15.14.6 дахь заалт, Барилгын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.3, 20.5, 20.6 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.15 дахь заалт, “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-ын 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 21/665/ТЗ тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нэгдүгээр хавсралтад заасан 1 /нэг/ аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг уг хавсралтад заасан барилгын ажлын төрлөөр 5 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Хоёрдугаар хавсралтад заасан 1 /нэг/ аж ахуйн нэгж, байгууллагад уг хавсралтад заасан барилгын нэмэлт ажлын төрлөөр тусгай зөвшөөрлийг олгосугай.
3. Барилгын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Гантулга/-т даалгасугай.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ /Д.Цэрэнжигмэд/-д даалгасугай.



Б.МӨНХБААТАР

151030633

Барилга, хот байгуулалтын сайдын  
2021 оны 09 дугаар сарын 24-ны өдрийн  
206 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**А. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН  
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ:**

1. "Риноконстракшн" ХХК, Зураг төсөл, сунгалт ЗТ-3.1, 6.1, 6.2, 6.3, 6.4, 8.1, 10.2 дугаар ажлын төрлөөр;

Барилга, хот байгуулалтын сайдын  
2021 оны 09 дугаар сарын 24-ны өдрийн  
00.6 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**Б. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН  
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НЭМЭЛТ АЖЛЫН ТӨРӨЛ ОЛГОХ:**

1. "Сипимедиа" ХХК, Барилга угсралт, нэмэлт БА-2.2 дугаар ажлын төрлөөр;

---oOo---